

Судалгааны Тойм

№4 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ТОВЧ ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийг 2002, 2015 онд шинэчлэн найруулж, баталсан бөгөөд эдгээр хуулиар хүүхдийн эрх ашгийг хамгаалах, ялангуяа бага насны хүүхдийг алах болон хүчиндэх үйлдлийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоож ирсэн. Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэж, хүүхэд хамгааллын төрийн бодлогыг тодорхойлж, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаа эрчимжиж байгаа хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурахгүй байна.

УИХ-ын Байнгын хороод хамтран зохион байгуулсан “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал” сэдэвт ерөнхий хяналтын сонголд оролцогчид 2015 оны Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, ялангуяа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялын бодлого сул, ижил төрлийн гэмт хэрэгт ялыг ялгамжтай оногдуулж байгаа тухай шүүмжилж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг сануулсан.

Тиймээс Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн судлаачид бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээнд

дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, зөвлөмж боловсруулахыг зорьсон билээ. Энэхүү тойм нь дээрх судалгаанд тулгуурласан бөгөөд боловсруулах явцад зайлшгүй шаардлагатай зарим статистик мэдээллийг шинэчиллээ. Уг тоймоор судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорьсон бөгөөд судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас татаж үзнэ үү.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны хүрээнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шүүхээс таслан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор шүүхийн шийтгэх тогтоол, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, статистикийн баримтад дүгнэлт хийх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, харьцуулалт хийх, санал асуулга, ярилцлага хийх зэрэг аргыг ашиглалаа. Мөн бага насны хүүхдийг алсан 40, бага насны хүүхдийг хүчиндсэн 68, нийт 108 шийтгэх тогтоолыг түүвэрлэн тусгайлан боловсруулсан загварчлалын дагуу дүн шинжилгээ хийлээ. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, оногдуулсан ялын үндэслэлийг тодруулах зорилгоор мөрдөгч, шүүгчийг хамруулан фокус бүлгийн ярилцлага хийсэн болно.

СУДАЛГААНЫ ДҮН

Нэг. Бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал

“Хүүхдийг ивээх сан”-гаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүүхдийн эрх чөлөөний төлөв байдал” судалгаагаар гэмт хэргийн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирч буй нөхцөл байдалд үндэслэн тухайн улс дахь хүүхдийн аюулгүй байдлын түвшнийг тодорхойлдог.¹ Монгол Улсад 2015 оноос 2020 оны эхний 10 сарын байдлаар хүнийг алах гэмт хэргийн улмаас 31 хүүхэд амь насаа алджээ. Харин бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг бага насны хүүхдийг алах гэмт хэргээс харьцангуй олон бүртгэгдсэн байна. Тухайлбал, 2015 оноос 2020 оны эхний 10 сарын байдлаар 1,305 гэмт хэрэгт 1,179 хүүхэд хохирчээ. Үүнээс 509 нь бага насны хүүхэд буюу 14 нас хүрээгүй хүүхэд хохирсон байна.

Хоёр. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогын өөрчлөлт

УИХ-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд хүнийг алах, 12.1 дүгээр зүйлд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээг өмнөх хуультай харьцуулахад хөнгөрүүлсэн. Тухайлбал, хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жилээр, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, цаазаар авах ялыг халж, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг хуульчилжээ.

Харин хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод, дээд хэмжээг өөрчлөөгүй, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн этгээдэд оногдуулах хорих ялын дээд хэмжээг 2 жилээр нэмэгдүүлсэн. Хорих ялын хэмжээ багассантай холбоотойгоор онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар энэ гэмт

хэргийг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, мөн цаазаар авах ялыг халж, харин үүний оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан.

Дээрх нэмэлт өөрчлөлт нь хүнийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг бууруулж, цаазаар авах ялыг халсан бөгөөд энэ нь эрүүгийн хуулийн ялын бодлогыг зөөлрүүлэх, нөгөө талаас Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой² холбоотой.

Мөн 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэгт бага насны хүүхдийг алсан тохиолдлыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан явдал нь цаг үеэ олсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн чухал алхам болсон. Харин хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогын хувьд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг өргөн хүрээнд хамгаалж, олон улсын жишигт нийцүүлэн хуульчилсан хэд хэдэн зохицуулалт оржээ. Үүнд:

- а) хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хүчээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн гэж тодорхойлсон;
- б) насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн тохиолдолд насны үечлэлээс хамааруулж ялын бодлогыг ялгаатай хуульчилсан (14-18 нас, 14-өөс доош нас);
- в) гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн;
- г) урьд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол тус тус хүндрүүлэхээр хуульчилсан зэргийг дурдаж болно.

¹ 2018 онд Монгол Улс 100,000 хүн амд 1.4 хүүхдийн амь нас хохирсон үзүүлэлтээр 176 орноос 76-д орсон байна.

² 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

Харин хоёр буюу түүнээс олон хүн, эсхүл удаа дараа бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд оногдуулах хорих ялын хэмжээ 20 жилээс хэтрэхгүй байхаар хуульчилсан нь олон нийтийн шүүмжлэлд өртсөөр байна. Дээрх арга хэлбэрээр үйлдсэн тохиолдолд бүх насаар нь хорих ял оногдуулах хуулийн зохицуулалт байгаа ч өнөөдрийн байдлаар шүүхийн практикт энэ төрлийн ял оногдуулсан тохиолдол байхгүй байна.

Гурав. Бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь 1) гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн таагүй орчин, 2) эцэг эхийн хараа хяналт сул байдал, 3) хүүхэд хамгааллын тогтолцоо бүрэн бүрдээгүй, үйл ажиллагаа нь оновчтой бус 4) ахуйн хүрээний архидалт, 5) нийтийн сүлжээний хяналтгүй байдал, 6) гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал (боловсролын түвшин, эрхэлсэн ажилгүй, хувь хүний төлөвшил, ёс суртахууны байдал), б) хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, хохирогчийг хамаарлаар нь авч үзвэл, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн 2.9, төрсөн хүүхдээ алсан 42.2, дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 40.2, төрөл, садны хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг тус тус эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 25, төрөл, садны хүний хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг эзэлж байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг гэр бүлийн хүрээнд, ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садны хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт

хэргийн 38.2, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь тус тус хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувийг тус тус хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садны хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 23,5 хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь 40.4 хувь нь дарамтад өртсөн, 20.3 хувь хууртагдсан, 17 хувь гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон (ээж, дүү), 19.1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй гэжээ. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотнын хүндээ шууд мэдэгддэг болох нь судалгаанаас харагдсан.

Дөрөв. Ял оногдуулсан байдал

Шүүхээс таслан шийдвэрлэсэн хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогыг өмнөх Эрүүгийн хуультай харьцуулан үзвэл, нэг удаагийн үйлдлээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 4.7 жилээр суларсан, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 1.5 жилээр чангарсан, удаа дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 3.7 жилээр суларч, бүх насаар хорих ял оногдуулаагүй, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулсан хорих ялын бодлого 4.4 жилээр тус тус чангарсан байна. Нийт

оногдуулсан ялын бодлогыг авч үзвэл, хорих ялын бодлого 0.7 жилээр чангарсан бөгөөд бүх насаар хорих ялыг хэрэглээгүй байна.

Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж, 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 22.2 жилийн хугацаагаар хорих эсхүл цаазаар авах ял оногдуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт дунджаар 14.2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байгаа нь өмнөх хуультай харьцуулахад ялын бодлого 7.9 жилээр суларчээ.

Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт тооцож байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд энэхүү үйлдлийг хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжид хуульчилснаар хүчиндэх гэмт хэргийн улсын хэмжээний статистик тоо нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын бодлого 6.3 жилээр чангарчээ.

ЗӨВЛӨМЖ

- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөр, хор уршгийг арилгах эрх зүйн зохицуулалтыг судалж, хэрэгжүүлэх;
- Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 20 жилээр тогтоох байдлаар Эрүүгийн хуулийн 1.10 зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, өршөөл, уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээ хэрэглэхгүй байхаар хуульчлах;
- Гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

СУДЛААЧИД:

Б.Энхболд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч
С.Гантулга, Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор
Б.Мөнхзул, Хууль зүйн магистр, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн багш

СУДАЛГААНЫ ТОЙМ БОЛОВСРУУЛСАН:

Б.Энхболд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор, ХЭҮК-ын гишүүн

САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.Хишигсайхан, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>
http://www.instagram.com/open_society_forum